

Биеийн тамирын багшийн ажил мэргэжлийн үйл ажиллагаанд тохиолддог саад бэрхшээлийн судалгаа

С.Бөхбат*

МУБИС, Биеийн тамирын сургууль, спортын тэнхим

Хураангуй

Энэ өгүүлэлд биеийн тамирын багшийн мэргэжлийн үйл ажиллагааны онцлог, тэдний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд нь тохиолддог саад бэрхшээлийн талаар авч үзсэн. Биеийн тамирын багшийн үйл ажиллагаанд тохиолддог саад бэрхшээл нь хувь хүн болон нийгмийн олон хүчин зүйлс байж болох бөгөөд үр дүн нь зогсонги байдал, үйл ажиллагааны завсарлалт, харилцааны хүндрэл гэх мэт олон хэлбэрээр илэрдэг. Судалгааны хэсэгтээ биеийн тамирын багшийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд нь тохиолддог саад бэрхшээлүүдэд статистикийн хүчин зүйлийн шинжилгээний аргыг ашиглан шинжилгээ хийсэн. Шинжилгээний үр дүнгээс нийтлэг тулгардаг саад бэрхшээлүүдийг бүлэглэн дараах гол хүчин зүйлс болгон ангиллаа. Үүнд 1. Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой хүчин зүйлс 2. Хувь хүний чадвар, үнэлэмжтэй холбоотой хүчин зүйлс 3. Нийгмийн хүчин зүйлс 4. Хувь хүний хөгжлийн хүчин зүйлс 5. Боловсролын тогтолцооны хүчин зүйлс байна. Мөн судалгааны үр дүн дээр үндэслэн биеийн тамирын багшийн онцлог, багшийн өөрийн хөгжих хүсэл тэмүүллийн ерөнхий дур зургийг авч үзэн, тэдний үйл ажиллагаанд тохиолддог саад бэрхшээл, хүндрэл бэрхшээлийг бууруулах арга замыг авч үзлээ.

Түлхүүр үг

Биеийн тамирын багш, үйл ажиллагааны онцлог, саад бэрхшээл, карьерын боломж

Удиртгал

Багшийн ажил мэргэжлийн хувьд тулгарч буй саад бэрхшээл нь сурган хүмүүжүүлэх үйл явцын үр дүнд шууд нөлөөтэй байдаг. С.Энхтүвшин, “Багшлахуйн үндэс” (2015) номдоо “Багшийн мэргэжил нь олон цагаар ажиллах шаардлагатай байдаг, эцэг эхчүүдийн дэмжлэг сул, шийдвэр гаргах эрх мэдэл хязгаарлагдмал зэрэг бэрхшээлүүдийн талаар дурдсан байдаг. Мөн энэ асуудлыг нийгэм, сэтгэл зүйн талаас нь Д.Катц, Л.Ли, Г.Лассвелл, М.Андерсон, Е.С.Кузьмин, Б.Д.Парыгин, Б.Ф.Ломов, Я.Л.Коломинский, Б.А.Климов зэрэг олон эрдэмтэд судалсан байдаг. Бид энэ өгүүлэлдээ биеийн тамирын багшийн ажил мэргэжлийн онцлог, багшлах явцад гарч буй хүндрэл бэрхшээлүүд, түүнд нөлөөлж буй гол хүчин зүйлүүд, тэдгээрийг бууруулах, түүнээс зайлсхийх зарим арга замыг тодорхойлох зорилго тавьсан юм.

“Биеийн тамирын багш”

Биеийн тамирын хичээлийг боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн дагуу зохион явуулах, суралцагчдын бие бялдрын хөгжил, эрүүл мэндийг дэмжих, стандартын шаардлагад

нийцсэн мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх мэргэжлийн үүрэгтэй ажиллана (YAMAT-08 ISCO-08, 2010).

Биеийн тамирын хичээл нь хуучин шигээ сурагч бүр дурладаг хичээл нь байхаа больж эхэллээ. Иймд багшид хүүхдүүдийг хөдөлгөөнд дуртай, биеийн тамирын дасгалаар хичээллэдэг, хөгжилтэй, эрүүл саруул биеэ авч явдаг байдлыг хангахын тулд хичээлийг зугаатай, тоглоомын хэлбэрээр явуулах шаардлага урган гарч байна. Энэ чиглэлээр биеийн тамирын багш нар нөхцөл байдлыг сайжруулан засахыг хичээж байгаа бөгөөд үүндээ сургалтын интерактив аргуудыг төдийгүй орчин үеийн техник, спортын хэрэглэгдэхүүнийг ашиглахыг чухалчилж байна (Маркова, 1993, х.7). Биеийн тамирын багшийн ажил нь авьяас сонирхол, тусгай ур чадвар, биеэр гүйцэтгэх, үлгэр дуурайлалтай байхыг шаарддаг онцлогтой.

Олон улсын ажил мэргэжлийн тодорхойлолтын 10 шинжүүрээр бид Биеийн тамирын багшийн ажил мэргэжлийг шинжиж дараах онцлогийг тодруулав (Бөхбат, 2018, х.51). Үүнд:

* ✉ bukhbat@msue.edu.mn

Хүснэгт 1
Биеийн тамирын багшийн ажил мэргэжлийн онцлог

Шалгуур	Тавигдах шаардлага
Ажлын мөн чанар	Хүнтэй харилцдаг, хүний бие бялдрын үзүүлэлт, эрүүл мэндэд хандах хандлага тодорхойлодог
Ажлын байрны нөхцөл	Шуугиантай, дуу чимээ ихтэй, хүүхэд бэртэх гэмтэх магадлал өндөртэй, уртасгасан цагаар ажилладаг
Тусгай шаардагдах чадвар	Авьяас, тусгай чадвар
Бие бялдрын эрэлт хэрэгцээ	Урт хугацаагаар зогсоно, дасгал бүрийг биеэр гүйцэтгэх чадвартай байх
Шаардлагатай бэлтгэл ажил	Спортын цолны шаардлага хангах, мэргэжлийн зэрэг авсан байх
Ажил эрхлэх боломж	Биеийн тамирын багшийн ажлын байрны орон тоо харьцангуй хомс, ажилд орсон хүн ур чадвар хүрэхгүй байгаагаас болж ажлаас гардаггүй
Боломжит орлого	Цалин бага, нэмэгдэл орлого олох боломжтой ч нөхцөл хязгаарлагдмал, илүү цагаар ажилласан хөлс олгодоггүй
Ажлын байрны аюулгүй байдал	Олон хүнтэй ажилладаг, дасгал бүр өөрийн аргачлалтай, гүйцэтгэх техниктэй иймээс эрсдэлтэй
Дэвших боломж	Ажлын мэргэжлийн зэрэг авах, спортын зэрэг цол авах, олон улсын шүүгч, гавьяат тамирчин, холбоодод ажиллах, хөрвөх
Нийгмийн байдал	Хувь хүний хөгжилд төдийлөн анхаардаггүй, хүмүүс ач холбогдол бага өгдөг. Нийгмийн зүгээс мэргэжлийн талаас үнэлдэггүй, авьяасын талаас сонирхдог, биеийн тамирын хичээлийг чухал гэж авч үздэггүй


Судалгааны хэсэг

2017-2018 оны байдлаар улсын хэмжээгээр биеийн тамирын багш 1951 байгаагаас эмэгтэй 567 байна. Эднээс манай судалгаанд Улаанбаатар хотын 18, Хэнтий аймгийн 2 ЕБС-ийн 53 биеийн тамирын багш хамрагдсан. Судалгааны асуулга дараах ерөнхий бүтэцтэй байсан.

1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл
2. Ажлын байрны өөрчлөлт хөдөлгөөн болон түүний шалтгааныг илрүүлэх асуултууд
3. Ажил үүргээ гүйцэтгэхэд нь тохиолдож буй саад бэрхшээлүүдийг тодорхойлох асуултууд
4. Саад бэрхшээлтэй нөхцөлд даван туулсан


арга замуудыг илрүүлэх асуултууд
Судалгааны мэдээллийг SPSS програм ашиглан боловсруулсан.

Зураг 1
Судалгаанд хамрагдсан сургууль




1. Судалгаанд оролцсон багш нарын ерөнхий мэдээллийг дараах графикаар харуулсан.
Судалгаанд Улаанбаатар хотын 18, Хэнтий аймгийн 2, нийт 20 сургуулийн 53 биеийн тамирын багш хамрагдсан.

Зураг 2
Судалгаанд хамрагдагчдын нас



Судалгаанд хамрагдагчийн дундаж нас 38.2 байна.

Зураг 3
Багшийн мэргэжлийн зэрэглэл, шагнал авсан байдал



2. Судалгааны “Та ажлын байраа сольж байсан уу? Хэдэн удаа сольж байсан бэ?” гэсэн асуултуудад 38% нь ажлын байраа сольсон, үүнээс

1 удаа сольсон 21.2%, 2 удаа сольсон 9.6%, 3 удаа сольсон 5.8%, 5 удаа гэж 1.9% хариулсан байна. Эндээс харахад судалгаанд хамрагдсан биеийн тамирын багш нарын 1/3 орчим нь ажлын байраа сольсон байгаа нь харагдаж байна.

Ажлын байраа солиход хүргэж буй шалтгаануудыг бүлэглэвэл 70 хувь нь ажлын байрны орчин нөхцөлөө сайжруулахаар, гэрт ойр байх, хөгжил дагаж захаас төв рүү шилжих хөдөлгөөн хийдэг болох нь харагдаж байна. Энэ нь биеийн тамирын багшийн ажил мэргэжлийн үйл ажиллагаанд ажиллах таатай орчин, нөхцөл, гэрийн хол ойр байдал нөлөөлж байгааг харуулж байна. 20 хувь нь биеийн тамирын багшийн мэргэжлийг илүү гэж үзэн ажил мэргэжлээ өөрчилж орж ирсэн байна.

3. Таны мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд тохиолддог томоохон хүндрэл бэрхшээлүүд юу байв? гэсэн нээлттэй асуултад хариулсан байдлыг авч үзвэл

1. Заал талбайн хүрэлцээ муу;
2. Хичээлийн хэрэгсэл, тоног төхөөрөмж муу;

3. Хагас бүтэн сайнд амралтгүй ажилладаг түүний хөлс мөнгө олгогддоггүй; зэрэг нь биеийн тамирын багшийн ажил эрхлэхэд учирдаг томоохон саад бэрхшээл болж байна.

4. Хүчин зүйлийн шинжилгээ

Судалгааны 3-р хэсэгт биеийн тамирын багшийн ажил мэргэжлийн үйл ажиллагаанд тохиолддог саад бэрхшээлийн хүчин зүйлийн талаар 26 асуулт байсан бөгөөд 1-огт үгүй, 2-бага, 3-дунд зэрэг, 4-их гэсэн Ликертийн хэмжээс бүхий хариулттай байсан.

26 асуултад хариулсан хариултын дунджийг тооцон, хамгийн өндөр байгаа үзүүлэлтүүдийг авч үзвэл дараах байдалтай байсан.

Хүснэгт 3

Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Хүчин зүйлсийн бүлэглэл	Factor						
	1	2	3	4	5	6	7
1. Сурган хүмүүжүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа ($\alpha=0.583$)							
Хариулт 24. Суралцагчдын сонирхолд нийцэхгүй хичээл зааж ор нэрийн төдий өнгөрөөж байсан	.855						
Хариулт 25. Суралцагчдыг хөгжих ёстой хувь хүн гэж харахгүй байсан	.839						
Хариулт 22. Өнгөрсөнд гаргасан алдаагаа засаж чадахгүй байгаа	.681						
Хариулт 19. Сурган хүмүүжүүлэх зорилго, зорилтоо дэвшүүлж шийдвэрлэж чадахгүй байгаа байдал	.671						
Хариулт 18. Миний заах арга зүйн түвшин дутмаг	.623	.439				.476	

Хүснэгт 1

Өндөр үзүүлэлттэй саад бэрхшээлүүд

Хариулт	Дундаж
1. Ажлын ачаалал их	2.75
2. Санхүүгийн байдал тааруу	2.37
3. Өөрчлөлтөд хангалттай уян хатан байж чадахгүй байгаа	2.23
4. Хөгжих боломж бага	2.06
5. Удирдлагын зүгээс ойлгохгүй	2.06
6. Сургуулиас багшийг идэвхжүүлэх олон хэлбэрийн ажил зохиодоггүй	2.06

Хүснэгтээс харахад биеийн тамирын багшийн хувьд ажлын ачаалал их, санхүүгийн байдал тааруу, өөрчлөлтөд дасан зохицох чадвар сул байгаа зэрэг нь ажил мэргэжил эрхлэхэд ихээр нөлөөлж байгаа голлох саад бэрхшээл болж байна.

Мөн 26 асуултын хариултыг авч үзэн Фактор шинжилгээ буюу хүчин зүйлийн шинжилгээ хийсэн.

Хүснэгт 2

КМО болон Barlett тестийн үр дүн

Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.		.798
Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square	381.465
	df	105
	Sig.	.000

Хүчин зүйлийн шинжилгээ хийхийн тулд КМО болон Bartlett тест хийсэн. КМО тест нь фактор бүрийн хувьд хангалттай хувьсагч хамрагдаж байгаа эсэхийг шалгадаг бөгөөд 0.7-оос их байх ёстой байдаг. Харин Barlett тест нь анхны хувьсагчид хангалттай хамааралтай байгаа эсэхийг шалгадаг бөгөөд p (sig) утга нь ач холбогдолтой ($p < 0.05$) байх шаардлагатай. Манай судалгааны хувьд дээрх шаардлагуудыг хангаж байгаа нь харагдаж байна.

Хариулт 23. Өөрчлөлтөд хангалттай уян хатан байж чадахгүй байгаа	.455					
Хариулт 26. Сургуулиас багшийг идэвхжүүлэх олон хэлбэрийн ажил зохиодоггүй						
2. Хувь хүний чадвар, үнэлэмж($\alpha=0.847$)						
Хариулт 9. Миний багшлах ур чадвар муу		.703				
Хариулт 13. Миний хувийн зан чанар нөлөөлдөг		.654				
Хариулт 7. Хамт олны таарамжгүй харьцаа		.634	.410			
Хариулт 17. Өөрийн хөгжил дутуу		.624				
Хариулт 14. Би өөрийн дуртай ажлаа эрхлээгүй		.610				
Хариулт 21. өөрийн үйл ажиллагаагаа бүрэн тодорхой илэрхийлж чадахгүй байгаа байдал	.406	.434				
3.Нийгмийн хүчин зүйл($\alpha=0.77$)						
Хариулт 10. Нийтэд танигдах байдал			.716			
Хариулт 3. Эрүүл мэнд			.556		.514	
Хариулт 6. Ажлын ачаалал их			.555			
Хариулт 8. Албан тушаал ахихгүй байна.			.551			
Хариулт 4. Удирдлагын зүгээс ойлгохгүй байна			.474	.452		
4. Хувь хүний хөгжил ($\alpha=0.566$)						
Хариулт 2. Санхүүгийн байдал				.723		
Хариулт 5. Мэдлэг чадвар бага		.556		.563		
Хариулт 1. Хөгжих боломж бага				.530		
5. Боловсролын тогтолцоо ($\alpha=0.650$)						
Хариулт 15. Магтаал урамшуулал байхгүй				.539		
Хариулт 12. Хүүхдийн хүмүүжил		.514		.534		
Хариулт 20. Боловсролын үйл ажиллагааны хэлбэр				.510		
Хариулт 16. Сургалтын үйл явц өөрөө бэрхшээл				.480		
7. Гэр бүл, гэрлэлт	.513					.633
Extraction Method: Principal Axis Factoring. Rotation Method: Varimax with Kaiser Normalization.						

Фактор онооны үндсэн дээр 26 үзүүлэлт дээрх байдлаар бүлэглэгдсэн байгаа бөгөөд тэдгээрээс

1. Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой хүчин зүйлс (6 хувьсагчийг төлөөлөх)
2. Хувь хүний чадвар, үнэлэмжтэй холбоотой хүчин зүйлс (6 хувьсагчийг төлөөлөх)
3. Нийгмийн хүчин зүйлс (5 хувьсагчийг төлөөлөх).
4. Хувь хүний хөгжлийн хүчин зүйлс (3 хувьсагчийг төлөөлөх).
5. Боловсролын тогтолцооны хүчин зүйлс (4 хувьсагчийг төлөөлөх) зэрэг нь гол хүчин зүйлс байна гэж үзэж болохоор байна.

Хүчин зүйлийн шинжилгээний үр дүнгээс харахад голлох хүчин зүйлсийн нийт хэлбэлзэл

өөрчлөлтөд эзлэх хувь дараах байдалтай гарч байна.

Хүснэгт 4

Хүчин зүйлсийн эзлэх хувь

Factor	Rotation Sums of Squared Loadings		
	Нийт %	Өөрчлөлтийн %	хуримтлагдсан %
1	4.129	15.881	15.881
2	3.895	14.979	30.860
3	2.393	9.205	40.065
4	1.687	6.489	46.554
5	1.671	6.428	52.982
6	.897	3.452	56.434
7	.863	3.319	59.753

Тухайлбал манай судалгаанд хамрагдсан биеийн тамирын багш нарын хувьд 1-р хүчин зүйл нь нийт хэлбэлзэл өөрчлөлтийн 15.881%, 2-р


хүчин зүйл нь 14.979%, 3-р хүчин зүйл нь 9.205%, 4-р хүчин зүйл нь 6.489, 5-р хүчин зүйл нь 6.428% -ийг эзэлж байна.

4. Харин дараагийн хүндрэл бэрхшээлээс гарах арга замуудыг асуусан асуултын хариултыг харахад аливаа хүндрэл бэрхшээл тулгарахад

1. Шинэ арга замыг хайсан
2. Өөрийгөө хөгжүүлсэн
3. Тэвчсэн гэсэн хариултауд хамгийн их сонголтыг авсан байна.

Зураг 4

Бэрхшээлээс гарсан аргууд



Аливаа хүндрэл бэрхшээлийг даван туулахад эхлээд түүнийг гэтлэх арга замыг хайн эрэлхийлж, өөрийгөө хөгжүүлэх талаар анхаардаг болох нь харагдаж байна. Харин тэвчсэн гэсэн хариулт их байгаагаас үзэхэд хүндрэл бэрхшээлийг туулах арга замаа мэдэхгүй идэвхгүй хандлагатай, тэвчих арга замыг сонгосон болох нь харагдаж байна.

Дүгнэлт

1. Судалгааны хариултауд дээр хүчин зүйлийн шинжилгээ хийсэн бөгөөд шинжилгээний үр дүнд биеийн тамирын багшийн үйл ажиллагаанд гарч буй саад бэрхшээлүүдийг

- Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой хүчин зүйлс
- Хувь хүний чадвар, үнэлэмжтэй холбоотой хүчин зүйлс
- Нийгмийн хүчин зүйлс
- Хувь хүний хөгжлийн хүчин зүйлс
- Боловсролын тогтолцооны хүчин зүйлс гэж ангилсан.

Эндээс харахад сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой хүчин зүйлс буюу мэргэжлийн мэдлэг чадвар, сурган хүмүүжүүлэх арга барил, мөн хувь хүний чадварыг сайжруулах нь нэн шаардлагатайг харуулж байна. Мөн сонгосон ажил мэргэжлийн сонголтынхоо

нийгмийн хариуцлагыг хүлээж, мэргэжлийн ур чадвараа хувьсан өөрчлөгдсөөр буй орчны нөхцөл байдлаас хоцроохгүй, шинэчлэн, тасралтгүй хөгжих үйл явц багш бүрд нэн чухал болж байна.

2. Биеийн тамирын багшийн ажил нь тусгай чадвар шаарддаг онцлогтой, багшаас хувь хүний хөгжилд анхаарах, шаардлагатай болох нь харагдаж байна.

3. Мэргэжил олгогч боловсролын байгууллага зөвхөн нэг ажлын байранд зориулж мэргэжилтэн бэлддэг тогтолцооноос аль болох зайлсхийх, тухайн мэргэжлийг эзэмших цогц чадамж дээр түшиглэсэн хөрвөх боломжуудыг санал болгосон карьерын боловсрол зайлшгүй олгох тал дээр анхаарах нь өнөөгийн хурдан хувьсан өөрчлөгдөх нийгэмд сэтгэл хангалуун ажиллах, амьдрах чадвартай иргэн төлөвшүүлэхэд хувь нэмэр болох юм.

4. Биеийн тамирын багш нарын хувьд тулгардаг заал талбайн хүрэлцээ муу, хичээлийн хэрэгсэл, тоног төхөөрөмж муу; хагас бүтэн сайнд амралтгүй ажилладаг түүний хөлс мөнгө олгогддоггүй зэрэг нь биеийн тамирын багшийн ажиллах сэдэл, амжилт гаргах нөхцөлийг нь сааруулж урам зоригийг бууруулдаг хүчин зүйлс бөгөөд эдгээрийг тулгамдсан асуудал болгон авч үзэж шийдвэрлэх нь чухал байна. Ингэснээр биеийн тамирын багш тогтвортой ажиллах, ажил мэргэжилдээ сэтгэлээрээ хандах, хөгжих нэгэн сэдэл болох үндэстэй гэж үзэж байна.

Ашигласан материал

Маркова, А.К. (1993). Психология труда учителя. Москва

Оюунчимэг, Д. (2017). *SPSS программ ашиглан тоон шинжилгээ хийх*. Улаанбаатар

Энхтүвшин, С. (2015). Багшлахуйн үндэс. Улаанбаатар

Бөхбат, С. (2018). *Биеийн тамирын багшийн карьерын байдал, түүнийг дээшилүүлэх боломж*. Улаанбаатар

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам. (2010). *Үндэсний Ажил Мэргэжлийн Ангилал ба Тодорхойлолт ISCO-08*. Улаанбаатар

<http://kursak.net/barery-v-pedagogicheskoy-vzaimodejstvii-obshhenii-i-uchebno-pedagogicheskoy-deyatelnosti/>© kursak.net

The study of physical education teachers activity and its barriers

S.Bukhbat

*Mongolian National University of Education,
School of Physical Education, Sports department*

Abstract

The paper intends to discuss about the main characteristics of professional activities of Physical Education Teachers and the common problems encountered by them. The most challenges facing with Physical Education Teachers are probably related to the individual and social factors, but there are different forms of problems, for instance, lack of communication skills, inactiveness, and frequent breaks in their actions and so on. The analytic methods were used to identify the statistical factors of problems facing with Physical Education Teachers. The outcome of the study has classified the most common problems into the following groups of influencing factors - (1) factors related to the pedagogical activities; (2) factors of individual skills and values; (3) social factors; (4) factors of individual development; and finally (5) factors of education system. Based on these outcomes of the study, it determines the general characteristics of Physical Education Teachers, their self-development interest and ambitions, and finds the ways to reduce those problems caused by the above factors.

Key words

Physical education teacher, activity characteristic, barriers, career opportunities